МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 22 өдөр Дугаар А/275 Мөрөн сум

Шугам сүлжээний ажлыг хүлээж
авах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.1, 48.6, Засгийн газрын 2020 оны 246, 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Их-Уул, Эрчим баг "Төмс хүнсний ногоо тариалдаг хөдөөгийн багуудын эрчим хүчинд холбох" ажлыг хүлээж авах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Б.Энхжаргал (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)
Гишүүд: Л.Аззаяа – Бүрэнтогтох сумын Засаг дарга
Х.Даваасүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн, Ерөнхий архитектор)
Г.Даваадорж (Хөвсгөл Эрчим Хүч ХХК-ийн ерөнхий инженер)
Ж.Жавзанпагма (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)
Ж.Нацагдорж (Онцгой байдлын газрын Гал түймрийн хяналтын улсын байцаагч, хошууч)
Зураг төслийн байгууллагын төлөөлөл:
Л.Ичинхорлоо ("Бодит чадал" ХХК-ийн инженер)
Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл: Б.Гантулга ("Энерго тех сервис" ХХК-ийн Ерөнхий инженер)
Ашиглагч байгууллагын төлөөлөл: С.Пүрэвдорж (Бүрэнтогтох сумын Их-Уул багийн Засаг дарга)
Э.Пүрэв-Очир (Бүрэнтогтох сумын Эрчим багийн Засаг дарга)

Комиссын нарийн бичгийн дарга: Н.Шинэбаяр (Хөвсгөл аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

2. Барилгын ажлыг хүлээж авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомж, Барилга, хот байгуулалтын яамны сайдын зөвлөмж, аймгийн Мэргэжлийн хяналтын газрын зөвлөмж, коронавируст халдвар (ковид-19)-аас урьдчилан сэргийлж, халдвар хамгааллын дэглэмийг баримтлан зохион байгуулж, комиссын ажлын

тайлан, шийдвэрийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд 2022 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн дотор танилцуулахыг Комиссын дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

3. Барилгын ажлыг хүлээж авахтай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Н.Шинэбаяр)-д үүрэг болгосугай.

4. Комиссын бүрэлдэхүүн чанаргүй барилга, байгууламжийн ажил хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай. 5.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН